

III. Монголын ойрхи түүхийн асуудал

1911 ОНЫ МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУВЬСГАЛД НӨЛӨӨЛСӨН ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛС

Т.Төмөрхүлэг

Монгол Улсын Их Сургууль, Түүхийн судалгааны хүрээлэн

Өгүүллийн товч утга: 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд Төвдийн хүчин зүйл дам нөлөөлж байсныг энэ өгүүлэлд гаргахыг хичээв.

Түлхүүр үг: Монгол-Орос, Орос-Төвд, Орос-Монгол

ЗХУ, БНМАУ-ын түүхчид 1911 оны Монголын үндэсний хувьсгалд Европ зүгийн хүчин зүйл, тухайлбал Оросын 1905 оны хувьсгал нөлөөлсөн гэж зохиол бүтээлдээ нутлахыг хичээж байв. Нэлээд сүүлийн жишээ татахад түүх судлаач Е.М. Даревская 1984 онд Эрхүүд хэвлүүлсэн номдоо: Оросын 1905 оны хувьсгалын мэдээ Монгол оронд түгэн тархаж “уг хувьсгалын Монголд үзүүлэх шууд нөлөөг батжуулж байсан юм”¹ гэж дүгнэжээ. Цагаагчин гахай жилийн хувьсгал гарахаас өмнөх үед, Оросоос ихэвчлэн түүх-археологийн судлалын эрдэмтэд, 1905 оны хувьсгалаас зугтсан болон худалдаа наймааны хүмүүс, цөөвтөр малын эмч нар /малд тарилга хийх/ Монголд зорчиж, Ар Монголын талаас бол умард нутгийн аянчин жинчид, мал тууварчид Оросын хил орчмоор очдог байсан зэргийг зохиогч номдоо дэлгэрэнгүй тоочиж энэ хүмүүс Оросын хувьсгалын үзэл санааг Монголд оршиж байсан оросууд /Дараевская авгайн мэдээлж буйгаар 1905-1907 онд 300-400 орос хүн Монголд амьдарч байсан бололтой/ хийгээд монголчуудад хувьсгалын тухай мэдээг хүргэж байсан нь гарцаагүй гэж батлахыг оролджээ. Гэтэл Монголын ноёд түшмэд, тухайн үедээ сэхээтэнд тооцогдвол зохих дээд, доод лам нар Орост гарсан тэр үймээн самууныг хэрхэн үзэж дүгнэж байсан талаар ямар ч баримт сэлт гаргаж ирсэнгүй. Зохиогч төдий л гол биш эрээвэр хураавар мэдээ сэлтийг хаман цуглуулж аль болохоор 1905 оны хувьсгал л Монголчуудад шууд нөлөөлсөн хэмээн нутлахыг хичээснийг туурвисан номынх нь үг үсэг бүхнээс төвөггүй ойлгож болно. Тэр үеэс Монголд ажиллаж байсан Троицкосавскийн Ардын Хурлын хорооны гишүүн, малын эмч А.П. Свечников гэгч өдрийн тэмдэглэлдээ бичихдээ, монголчууд Орос оронд самуун дэгдсэний учрыг мэдэхийг хичээж элдэв зүйл шалгаахад нь “Удирдагч нартаа

¹ Е.М. Даревская, Проникновение сведений о русской революции 1901-1907 гг. В Монголию, в кн: Россия и страны Востока в середине XIX – начале XX вв. Иркутск, 1984, стр. 60.

сэтгэл дундуур байгаагаа харуулсан хэрэг ээ” гэж хариулахад “Удирдагчийнхаа эсрэг босч яаж болноо, удирдагч үгүйгээр та нар яаж амьдрах юм бэ?” гэж гайхдаг байлаа гэжээ². Бидний үзэж байгаагаар тухайн үеийн жирийн монголчуудын нийгэм-улс төрийн үзэл саналга, төр засгийн талаарх сэтгэлэг /mentality/ ямаршуу байсныг Свечниковын бичсэн энэ зүйл ч тайлбарлалтгүй хэлээд өгч байх мэт. Зөвлөлтийн болоод БНМАУ-ын түүхчид 1911 оны Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөнийг 1905 оны Оросын хувьсгалын шууд нөлөө гэж батлахыг илтэд чармайж байсан нь “1905 оны хувьсгал бүх Азийг хөдөлгөөнд оруулахад хүргэв” гэж Лениний нэг бус удаа тэмдэглэн ярьж байсанд таацуулах гэсэн тэр үеийн үзэл суртлын амьсгалаар гарч ирсэн оролдлого гэж үзэхээс өөр аргагүй. Үнэндээ Тогтох тайжийн хятадуудын эсрэг боссон /1905-1907 он/ хийгээд Ард Аюуш хошуу ноёнттойгоо заргалдсаныг Оросын 1905 оны хувьсгалтай дам бусаар ч холбон үзэх гэхэд тодорхой баримт хэрэглэгдэхүүн ер олдохгүй байна. 1910 онд Ерөөгийн ноос угаах үйлдвэрийн монгол ажилчид эзэдтэйгээ эвдэрснийг бас 1905 оны хувьсгалтай уялдаатай гэж бардаагаар хэлэхэд хэцүү юм. 1990-ээд оноос Оросын монголч эрдэмтэд энэ эндэгдлийг засахыг мэрийж буй нь тон сайшаалтай. Тухайлбал, түүхч Е.А.Белов 1997 онд хэвлүүлсэн нэг сэдэвт бүтээлдээ “архивын хэрэглэгдэхүүнээс үзвэл, 1905 оны Оросын хувьсгал монголчуудад чухамдаа нөлөөлөөгүй байна”³ гэж дүгнэжээ. Үүнийгээ, тэр үед Монголд орчин үеийн саналга сэтгэлэг бүхий сэхээтэн байгаагүй, хөрөнгөтний ардчилсан хувьсгалын болоод бүгд найрамдах үзэл санааг хүлээн авч чадахгүй асан”⁴ гэж тайлбарлажээ. Ийм санааг 2005 оны эхээр миний бие МУИС-д түүх бичлэгийн сэдвээр болсон эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан хавсралт илтгэлдээ цухас дурдсан билээ.

Мөн түүхээс үзвэл Монголын үндэсний хувьсгалын хөдөлгөгч гол хүчин нь жирийн ард олон байгаагүй, энэ хувьсгалд тэд бие даасан үүрэг гүйцэтгээгүй гэсэн дүгнэлтийг зөвшөөрөхөөс өөр аргагүй. ЗХУ-д өөрчлөлт шинэчлэл нэгэнт эхлэсэн үе буюу 1988 онд, энэ өгүүллийг чадан ядан бичигч Москва хотноо Дипломатын Академид эрдмийн зэрэг хамгаалсан зохиолдоо 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд дээд ноёд, лам нарын оролцоо эрхбиш байсныг зохих хэлбэрээр цухас

² там же, стр. 69.

³ Е.А.Белов, Россия и Китай в начале XX века
Русско-китайские противоречия в 1911-1915гг. Москва ИВ РАН 1997, стр. 26

⁴ там же

боловч дурдсан билээ. 1911 оны эцсээр Монголд гарсан үндэсний хувьсгал нь эхлээд төрийн эргэлтийн хэлбэрээр гарсан гэдгийг хэн хүнгүй мэдэж байгаа. Гагцхүү VIII Богд Жавзундамба тэргүүтэй том хар шар феодалууд Хятадаас салж, үндэсний тусгаар тогтнох их үйл хэргийг эхлүүлж шүтлэгтэн олныхоо хүсэл эрмэлзлийг аль нэг хэмжээгээр бодолцож байсан тул зүй ёсоор энэхүү хөдөлгөөнийг үндэсний хувьсгал гэж нэрлэх болсон нь судлаач миний бодоход тон оновчтой юм.

VIII Богдын Манж-Хятадын эрх мэдлээс ангижрах гэсэн санаа аль 1891 оноос цухалзаж байсан нь тэр хүний лүндэн гэж нэрлэж болох аман өгүүллэг зэргээс ч мэдэгддэг юм⁵. Дээрхийн гэгээн болон бусад том ноёд, лам нар юуны өмнө Чин улсын байдлыг хянамгай ажиглаж, эгзэгтэй гэсэн зүйлд чих тавьж байсан нь лавтай. Дээрхийн гэгээн 1900 онд Оросын Цагаан хаанд элч зарж Манжаас салахад туслахыг гуйсан нь /Дилав хутугтын дуртгалд тодорхой байгаа билээ/ Манж гүрэнд Ихэтуаны буюу Боксёрын бослого гарсан жил билээ. Тэр жилийн нүргээнтэй үйл явдал мөн оны есдүгээр сард буриад-монгол гаралтай Агваан Доржиев Цагаан хаан II Николайд хоёр дахь удаагаа бараалхаж, Төвдийг Английн түрэмгийлэлээс хамгаалж Оросын өмгөөлөлд авахуулах зорилгоор хэлэлцээ хийгээд тэндээсээ шууд Их хүрээнд ирсэн жилтэй давхцаж байгааг бас анзаарууштай юм. 1895 онд Богд Живзундамба хутугт Оросын хаанд элч илгээсэн гэсэн яриа бас буй. Гэвч батлаж нутлах баримт олддоггүй. Хэрэв ийм явдал үнэхээр болсон бол энэ онд Манж Чин улс Японы албадлагаар хэлэлцээ хийж Солонгосын "тусгаар тогтнол"-ыг хүлээн зөвшөөрч Пескадорын арал, Ляодуны хагас арал, Порт-Артурыг Наран улсад найр тавин өгсөн билээ. 1911 оны сүүлчээр Монгол улсын тусгаар тогтнолыг сэргээснийг зарлан тунхагласан нь Манж гүрэнд Синьхуайн хувьсгал их сүр бараатай эхлээд байсан үе юм. Тэгэхээр Ар Монголын эрх баригчид өөрсдийн санааг гүйцэлдүүлэхийн тулд чухамхүү аятай цаг үеийг анан отоож байсан нь илэрхий байдаг юм.

Энд өгүүлэгдэн буй Агваан Доржиевын нэр Монголын түүхэнд тэр болгон дурдагддаггүй. Тэр бол Хори буриадын галзут овгийн хүн бөгөөд 1853 онд төржээ. Арван есөн насандаа Ар монголын хүн гэсэн нэрээр Төвдөд очиж /Жич: Тэр үед Төвдөд Оросын харъяатыг нэвтрүүлдэггүй байжээ/ Брайбун хийдэд чойрын ном үзэж эхлээд 1888 онд лхаарамбын мяндагт хүртээж XIII Далай ламын ном хаялцах хичээл сургуульд цанид хамбын зэрэгтэйгээр дэвшин оржээ. Ийнхүү Далай ламд тоогдон

⁵ Г.Жамсранжав.Богд хаан /Хурмаст хааны элч/,УБ., 1998, 26-29 дэх тал

ойртож танилцаад 1888 онд Их Британи Сиккимийн хил орчим цэрэг зэвсгийн үйлдэл хийсэн цагаас Төвдийг аврах ганц арга бол Баатар цагаан хааныг түших явдал мөн гэж түүнд уйгагүй ухуулан сэнхрүүлж эцсийн бөлөгт итгэлийг нь авсан хүн билээ. 1907 оны эцсээр Агваан Доржиев Оросын Гадаад харилцааны Яаманд өгсөн нууц захиандаа: "Япон Монголд, Англи Төвдөд "Оросыг өдөөн хатгаж байна". /Жич: Ар, Өвөрмонголыг нөлөөнийхөө хүрээнд хуваан авах тухай Орос, Японы 1907, 1910, 1912 оны нууц хэлэлцээр буй/.

Орос улс Монгол, Төвдөд нөлөөгөө нэмэгдүүлж, эдгээр оронд "соёл-эдийн засгийн байлдан дагууллыг тайван замаар хийвэл зохино". "Энэхүү тайван маягийн байлдан дагууллыг" Монгол, Төвдөд Оросын хийгээд орон нутгийн үндэсний худалдаа, аж үйлдвэрийг хөгжүүлэх, язгуур үндэсний болоод, шашин суртал, ахуй амьдралын өвөрмөц онцлогийг нь хөндөлгүйгээр монгол, төвд түмнийг гэгээрүүлэх, ийм л хоёр замаар хэрэгжүүлж болох юм" (Е.А.Беловын Россия и Китай в начале XX века номын 260 дахь талд үзмүү) гэж өгүүлжээ. Түүнчлэн Агваан Доржиевыг Төвд, Монголын тусгаар тогтнолын асуудлаар XIII Далай лам, Хутугт хоёрын нууц харилцаанд ихээхэн зүтгэж явсан хүн гэж үзэх учир шалтгаан бий. Агваан Доржиев бас Их Британий эзэнт улсын өөдөөс Төвдийг Оросын өмгөөлөл хамгаалалтайгаар Хятадаас салгаж болно гэсэн бодолдоо итгэж үнэн сэтгэлээсээ чармайж явсан зүтгэлтэн болохыг нь үгүйсгэх учиргүй. Английн нууц албаныхан нэгэн үе түүнийг Оросын хааны тагнуул хэмээн хардаж толгойг нь авчирч өгсөн хүнд 10 000 рупи шагнана гэж олон улсын хэмжээнд зар тарааж байсан үе бий. Гэвч англичууд 1912 оноос түүнийг хардаж сэрдэхээ нэгэнт больжээ. Үүнд Агваан Доржиев Цагаан хааны тагнуул биш юм байна, өөрийнхөө үзэл бодолд хөтлөгдсөн хүн юм байна гэдэгт итгэсэн хэрэг.

Дашрамд дурдахад 1900 онд Хутугтын Оросын Цагаан хаанд илгээсэн төлөөлөгчдийн улс төрийн цаад учир зорилгын тухайд архиваас тодорхой баримт сэлт одоогоор олдоогүй. Харин Английн Register Annual /Жилийн мэдээлэл" сэтгүүлийн 1900 оны дугаарт "Монголын хутугт Оростой найрамдах сэтгэлээ илэрхийлж өөрийн итгэлт хүнээр уламжлуулан Хятадын засгийн газрын өрийг төлөхөөр 100 000 сая рубль зээлдүүлэхийг 1900 оны эхээр хүсэв. Витте бээр Хутугтын орлогоор барьцаа тавьж, 30.000 рублийг 8 хувийн хүүтэйгээр зээлдүүлэхийг хаанаар зөвшөөрүүлжээ. Гэтэл хутугтын элч ийм тусламж өгөх гэсэнд талархаад

авахаас цааргалжээ”⁶ гэсэн л мэдээ буй. Яг ийм мэдээг түүхийн шинжлэх ухааны доктор О.Батсайхан Санкт-Петербург хотын Түүхийн архивт хадгалагдаж буй Монголын түүхэнд холбогдох хэргээс олж үзсэн байна. Сая нэр гарсан Сергей Юльевич Витте бол язгууртан гарвалтай бөгөөд тухайн үед Сангийн Яамны сайдын алба хашиж байсан хүн. Монголын төлөөлөгч олгосон зээлийг нь авахаас татгалзсан нь О.Батсайханы бичсэнчлэн “Хятадын өр төлөөсийг барагдуулах нэрийн дор зээл хүссэн хэрэг боловч үнэн хэрэг дээрээ Монголын талаархи Оросын байр суурийг тандах зорилготой байсан хэмээн үзэж болох мэт”⁷.

Энэхүү Витте Монгол, Төвдийг Орост нэгтгэж авах тухай Цагаан хааны хайртан Петр Бадмаевын төлөвлөгөөг их л сонирхон бүтэх эсэхэд нь эргэлзсэн ч “оролдоод үзэхэд илүүдэхгүй” хэмээн уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хоёр сая алтан рубль олгохоор төсөвлөхийг зөвшөөрч байсаныг бодоход Орос гүрний нөлөөний хүрээг өргөжүүлэх талыг ихэд барьж явсан сайд мөн нь илэрхий бөгөөд Богд хааны элчид улс төрийн бодлогын үүднээс уриалгахан ханджээ гэж үзэхэд болохгүй гэх газаргүй.

1904 оны 5 дугаар сард Английн цэрэг Зана голын нөгөө эрэгт тулж ирэхэд XIII Далай лам Агваандоржиевтэй зөвшилцөж, намар нь оргох маягаар Монголд зорьж ирсэн нь хоёр зорилго агуулжээ гэж үзэж болмоор байна. Үүнд, нэгд, англичууд юмуу хятадын эрхтэн нараас амь насаа хамгаалахын сацуу дөхмийг бодож Оросын хил ойролцоо Ар Монголоос Оросын хаантай болон дээд албаныхантай холбоо барих тэндээс хамт дагалдаж ирсэн Агваан Доржиевыг Санкт-Петербург руу илгээж Цагаан хаанаас Төвдийг өмгөөлөлдөө авахыг хүсэн соёрхох, хоёрт, VIII Богд Жавзандамбатай нүүр учран уулзаж Төвд, Монголын хэтийн хувь заяаны талаар санаа бодлоо солилцох, үйл ажиллагаагаа нэгтгэхэд оршиж байсан нь архивын баримтаар эдүгээ илэрхий болж буй.

Гэтэл Чин улсын хааны зарлигаар Монголд цагаачилж очсон Далай ламд зохих ёсны дээд хүндэтгэлийг үзүүлэхгүй байхыг Хутугтад мэдүүлж, Ховд, Улиастай Өргөө хотод сууж байсан амбан нартаа Далай ламыг хатуу харгалзаж, Оросын хилээр гарах оролдлого хийх аваас яаралтай мэдэгдэхийг чандлан тушаасан ажээ. Ийм хэцүү мөрдлөгийн дунд Далай лам, Хутугт хоёр хоёр ч удаа сэм уулзсан⁸ нь өвгөн

⁶ Annual Register, 1900, p. 327

⁷ О.Батсайхан, Богд хаан бүр 1900 онд Оросын цагаан хаанд хандаж байжээ. Өнөөдөр, 1998.5.2, №88/382/

⁸ Ц.Дамдинсүрэн, Түүвэр зохиол, “Өвгөн Жамбалын яриа”, УБ, 1969, 718-719 дэх тал.

Жамбалын ярианаас мэдэгдэж байгаа юм. Өвгөн Жамбал Богдын донир явсан хүн, Далай лам, Богд хоёрын харилцааны талаар нэлээд юм дуулж мэдсэн байж болзошгүй. Академич Б.Ширэндэвийн туурвисан “Сэрэл” түүхэн найруулал хэмээх номд Далай лам, Жавзандамба хутугт хоёрын ярианы товч тэмдэглэл гэмээр зүйл буй⁹. Гагцхүү зүүлт сэлт байхгүй юм. Би Б.Ширэндэв гуайгаас 1997 онд “Та тэр тэмдэглэлийг бичихдээ ямар эх сурвалжид тулгуурласан бэ?” гэж асуухад өвгөн Жамбалын нэрийг зааж байсан.

Түүхчдийн бичиж нийтлүүлсэн зүйлд Далай ламыг Монголд байхдаа Оросын эрдэмтэн П.К.Козлов, Бээжинд сууж байсан Оросын элчин төлөөлөгч Д.Д.Покотиливоос өөр ямар нэгэн орос хүнтэй харилцаж ярилцсан тухай мэдээ баримт байдаггүй. Чингэтэл Хиагтын хилийн комиссар дэд хурандаа А.Д.Хитрово авгайн бичсэн Далай ламын 1905-1906 онд Монголд хийж байсан үйл ажлын талаарх тэмдэглэлийг Оросын эзэнт улсын гадаад бодлогын архиваас эрдэмтэн Белов олж үзсэн нь тон ч олзуурхууштай. Белов доктор Хитрово авгайн “Записка” хэмээх эл тэмдэглэлийг “Монголын чөлөөлөх хөдөлгөөнд Төвдийн дээд эрх баригчдын томоохон үүрэг гүйцэтгэснийг гэрчлэх ховор чухаг баримт бичиг”¹⁰ гэж үнэлэн үзжээ. Хитрово мөнөөх Д.Д.Покотиловын удирдамжаар Далай ламыг Вангийн хүрээнд байхад нь өөрийн нууц туршуулуудаараа дамжуулж түүнтэй холбоо барьж харилцаж байжээ. Далай лам Оросын туршуулуудад, Төвд, Монголын алс ирээдүйн талаар үзэл санаагаа илэрхийлэхдээ, “Төвд ч, Монгол ч хэзээ ч Хятадын дарлалд оршиж байгаагүй, Монгол бол харин ч Хятадыг эзэрхийлж байсан, одоо Манжийн эзэнт гүрэн унах нь илэрхий болсон тул Монгол, Төвд хоёр биеэ даасан улс болох ёстой, Манжийн хаанд бид чинь сайн дураараа захирагдаж орсон улсууд юм шүү дээ” гэх зэргээр ярьдаг байжээ. Энэ үг утга санааны хувьд төдийгүй үг үсгийн хувьд ч Монголын дээдчүүлийн Манжаас салах үед гаргаж ирж байсан шалтагтай их адилхан байгаа нь сонин. Далай лам энэ номлолоо Монголын ноёд, томоохон лам нартай олонтаа хэлэлцдэг асан гэнэ¹¹. Хитрово гуай бичихдээ, Далай лам Вангийн хүрээнд морилж байхдаа өдөр бүр хэдэн зуун мөргөлчдийг хүлээн авч адис хүртээдэг байсан. Харин ноёд, гэгээнтэн лам нар, тэдний элч төлөөлөгч нартай бол тусгайлан ярилцдаг

⁹ Б.Ширэндэв, Сэрэл, УБ., 1990, 38-40 дахь тал

¹⁰ Е.А.Белов, Россия и Китай в начале XX века Русско-китайские противоречия в 1911-1915. Москва ИВ РАН, 1997, стр. 118.

¹¹ там же, стр. 267

бөгөөд уулзалт нь “жинхэнэ улс төрийн зөвлөгөөний шинж чанартай болдог байлаа” гэжээ. Хитрово авгайн цааш өгүүлснээр, эдгээр уулзалт, зөвлөлдөөний дүнд, “Хятадаас салж [Монгол-Төвдийн] бие даасан холбооны улс болох, үүнийг Оросын өмгөөлөл, дэмжлэгтэйгээр хулганы ч хамраас цус гаргалгүйгээр гүйцэтгэхээр эргэлт буцалтгүйгээр шийдвэрлэв”¹² гэж тогтжээ.

Хитрово ноёнтны бичсэнээр, Далай ламтан бээр “Орос улс Монгол,Төвдийн хүсэл шаардлагын чин үнэнч гэдгийг хүлээн, уг асуудлаар Далай ламын учир тайлбарыг ухаарч, улмаар Европын бүх том гүрнээр хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр оруулах юм бол эдгээр гүрэн энэ хүсэл шаардлагын хууль ёсны болохыг үл огоорч эс чадна гэдэгт итгэж байгаа юм. Оросын дэмжлэг, өмгөөлөл гэдэг нь үүнд оршиж байгаа юм” хэмээн учирлаж байжээ. Гэвч тэр үес Хаант Оросын засгийн газар улс төрийн хувьд болгоомжтой бодлого баримталж байсан бөгөөд Төвдийг Английн түрэмгийллээс хамгаалж байсан хир нь /Орос, Английн 1907 оны хэлэлцээр/, тус орныг тусгаар тогтноулах үйлдэл хийгээгүй. Орос улс хэдэн жилийн дараа өмгөөлөлдөө авсан Монголын тухайд ч тийм үйлдэл хийх хүсэлгүй байсан юм. Учир нь гэвэл тэр үеийн томоохон гүрнүүд тухайлбал Орос, Япон, Герман, Франц, Их Британи нөлөөнийхөө хүрээг алдахгүй бодлого баримтлахын сацуу өвөр хоорондоо холбоотны харилцаагаар нягт холбогдож эрх ашгийнхаа үүднээс Хятадын “газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хөндөхгүй”, Орос-Японы дайны дараагаар Алс дорнодод тогтсон улс төрийн тогтвортой байдлыг бусниулахгүй гэсэн чиглэлээр нэгдмэл байр суурьтай байж билээ.

XIII Далай ламын Хятадаас туурга тусгаар Монгол-Төвдийн Холбооны улс буй болох гэсэн санаа судлаачдын анхаарлыг бас татах учиртай. Агваан Доржиев 1912 оны өвөл Нийслэл хүрээнд ирж Монгол-Оросын хэлэлцээрт Оросын талын төлөөлөгчийн тэргүүнээр оролцсон, элчин сайд ноён Иван Яковлевич Коростевицтой уулзахдаа, “Лхасс хотын эрх баригчид Халхтай ойртохыг хүсэхдээ, Далай лам өөрийн тэргүүлэх зиндаандаа нийцүүлэн найртай ёсыг үзүүлдэг ч Өргөө хотынхон түүний улс төрийн манлайллыг хүлээн зөвшөөрөөсэй билээ”¹³ гэжээ. Үүгээр Доржиев Төвд, Монгол хэтдээ ойртох учиртай юм гэсэн санааг битүүхэн зааж хэлэх гэсэн бололтой. Олноо өргөгдсөний хоёрдугаар оны 12 дугаар сарын шинийн гурванд

¹² там же, стр. 119 /АВПРИ, китайский стол, 4, д.409, л.312/

¹³ Иван Николаевич Коростевиц, От Чингис хана до Советской Республики, УБ., 2004, стр. 291-292

Монгол, Төвдийн хооронд тогтоосон найрамдлын гэрээ бичигт гарын үсэг зурсны дараа Агваан Доржиев саяхь баримт бичгийг Коростовец ноётонд танилцуулах ялдар нэг шашинтай, адил үндэс угсаатай, аль аль нь Хятадын дарлалд хаширсан хоёр улсын утгасоёлын болоод улс төрийн нэгдлийн төлөө аль хэдийнээс эрмэлзэгч Далай ламаас хэлэлцээр байгуулах санаачилга гарсан юмаа¹⁴ гэж ярьжээ. Үүнийг, Ар Монгол Хятадаас салж тусгаар тогтнолоо зарласанд Далай лам зоригжиж ойртон нягтрах эрмэлзлээ бичгийн хэлбэрт оруулахаар шийдсэн хэрэг гэж үзүүштэй байгаа юм. Уг хэлэлцээр¹⁵ есөн зүйлтэй бөгөөд Монгол, Төвд хоёр өөртөө эзэрхэх улс төр байгуулсныг тус хоёр улсын хаан эзэн Жавзандамба хутугт, Далай лам хоёр харилцан сайшаан зөвшөөрч, Буддагийн шашныг хамгаалах, гадаадын болоод дотоодын дайсны эсрэг бие биедээ туслах үүрэг хүлээжээ. Энэ хэлэлцээрт хоёр улс Хятадаас ангижирч алсдаа холбооны улс байгуулна гэх мэт үг үсэг байхгүй. Энэ нь дээр өгүүлснээс үзэх юм бол Далай ламын санаачилга ч байж болзошгүй. Хэрэв тийм санааг мөнөөх хэлэлцээрт тусгалаа гэхэд Англи ч, Орос гүрэн ч огт таашаахгүй нь ойлгомжтой байсан цаг. Английн засгийн газар Монгол, Төвдийн хэлэлцээрийг эсэргүүцсэний хариуд Оросын Гадаад хэргийн Яамны сайд Сазанов Доржиевыг Далай ламын албан ёсны төлөөлөгч гэж нэг их тооцохгүй байгаагаа мэдэгджээ. Тэгвэл Агван-Доржиев Далай ламын заавраар II Николай хаантай Төвдийн асуудлаар олонтаа уулзаж ярилцсан баримт бэлээхэн буй, бас одоо үеийн Оросын хэвлэлд бичсэнээр, Доржиевын Далай ламтай болон Оросын албан ёсны зохих хүмүүстэй харилцаж байсан бичиг захидлуудаас үзэхэд олон жилийн туршид Далай ламын итгэл найдварыг бүрэн хүлээж, албан ёсны өндөр дээд байр суурь эзэлж явсан нь илэрхий, тэгснээрээ ч төрийн чухал чухал хэлэлцээ хийж, зохих ёсны баримт бичигт гарын үсэг зурж байжээ хэмээн өгүүлсэн буй.

Нөгөөтэйгүүр, Доржиев, Энэтхэгийн засгийн газрын албан ёсны хэвлэл "Пионер" сонинд бичсэнчлэн, Монголтой хэлэлцээр байгуулснаар Оросын дипломат

¹⁴ Николай Кулешов, Как Монголия и Тибет признали обоюдную независимость. О внешнеполитической деятельности Агвана Доржиева. Журнал "Священный Байкал, Улан-Удэ, Спецномер, 1995, стр. 18-19

¹⁵ Л.Дэндэв, XX зууны Монголын түүхийн эх сурвалж (1911-1921) /Автономит Монгол улсын онцлог баримт бичгүүд, УБ., 2003, 194-195 дахь тал

үйл ажиллагааг Төвдийн талаарх яриа хэлэлцээнд татан оруулах далдын хүсэл өвөрлөжээ¹⁶ гэсэн нь магадтай бизээ.

Юутай ч XX зууны эхний арав гаруй жилийн хугацаанд Монгол, Төвд хоёр тусгаар улс болох хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдөн харилцан нөлөөлж байсан нь дээрх баримт сэлтээс үзэхэд маргах зүйлгүй. Ялангуяа XIII Далай ламын Монголд ирсэн 1904 оноос эл ажиллагаа сүрхий идэвхижсэн нь тодорхой. Учир зүйн талаас нь ч аваад үзэхэд эрт цагаас тусгаар улс явсан түүхтэй, өвөрмөц онцлогтой хоёр том үндэстэн өөрсдийг нь атгаж байсан их гүрний эрхшээлээс гарахад бие биедээ дэм болохыг эрмэлзэх нь зүйн дагуу хэрэг байсан гэлтэй. Монголын хутугт Жавзандамба болон ноёд, томоохон лам нарын тухайд Хятадаас тусгаарлахад хойд хөрш Орос улсыг гол түшиг тулгуураа гэж үзэж байсан ахул Төвдтэй хэдэн зуун жилийн нягт хэлхээ холбоотой явж ирсэн хийгээд шашин шүтлэг нэгтэйн хувиар Далай ламын зүгээс үзэл бодлын нөлөө дэмжлэг авсан төдийгүй, 1911 онд бүрэн эрхт байдлаа тунхагласныхаа дараа эргээд бас тэдэнд нөлөөлж, улс төрийн талаар тийнхүү нягт холбогдож агсныг манай Монголын үндэсний хувьсгалын түүхэнд эрхбиш тэмдэглэх буй за.

Abstract: Annotation of the article "External factors of the Mongolian National Revolution of 1911" It has been commonly viewed by the historians of the USSR and the People's Republic of Mongolia that the national liberation movement of Mongolia in 1911 was influenced directly by the 1905 Revolution in Russia. However, the historians failed to provide convincing evidences supporting such argument. The argument, influenced by the political and ideological dogmatism of the given time was made in an attempt to please Lenin's statement "1905 Revolution awakened all Asia". However, the disclosure of archives, especially those in Russia, has enabled today's historians to research and suggest new conclusions on the subject. For instance, documents found in the Russian Empire's foreign policy archives have brought the author to the conclusion that the 1905 Revolution in Russia had no impact at all on the Mongolian national liberation movement of 1911. The realistic evidence lies in the fact that Mongolia had nor the intelligentsia with

¹⁶ Л.Б-Н, Хамбо-Агван-Доржиев (К борьбе Тибета к независимости), Новый Восток журнал, Москва, 1923, стр. 150

modern thinking and neither the foundation to absorb the ideas of the bourgeoisie democratic revolution or the republicanism at that historical turn.

Further, the author bases himself on the new conclusion that the Mongolian national liberation movement was effected by the Tibetan factors. The cultural and religious bonds maintained for many hundred years between these two nations (Mongolians and Tibetans) who were subjects of the Mandchuria Dynasty, became the foundation for establishing political relations at the beginning of XX Century. Based on authentic documents, the author has made attempts to prove Dalai Lama XIII were strengthened from 1904 and the parties came to agreement to cooperate in gaining independence from the imperialistic dynasty. Thus, this argument is raised for the first time in the modern history of Mongolia.

Ном зүй

1. Г.Ц. Цыбиков, Избранные труды, О центральном Тибете, Монголии и Бурятии, т.2, Новосибирск, 1991
2. Г.Навааннамжил, Өвгөн бичээчийн өгүүлэл, УБ, 1956
3. Дилав хутугт Б. Жамсранжав, Ариун сэтгэл, авралын үндэс (Дуртгал, намтар, өгүүлэл), УБ, 2000
4. Ш. Нацагдорж, Халхын түүх, УБ, 1963
5. Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудал, (1911 оны үндэсний хувьсгалын 90 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын материал), УБ, 2002
6. Богдын лүндэн, УБ, 2002
7. Чийрэгхүү, Жавзандамба хутугтын товч намтар, Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо, 1992
8. Д. Гомбосүрэн, Зоригт баатар Э.Тогтох, УБ, 2003
9. Л.Жамсран, Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт, УБ, 1997
10. Ц. Пунцагноров, Монголын автономит үеийн түүх, /1911-1919/, УБ, 1955
11. Ш.Сандаг, Монголын улс төрийн гадаад харилцаа, 1850-1919, 1, УБ, 1971
12. Л.Дэндэв, XX зууны Монголын түүхийн эх сурвалж (1911-1921), УБ, 2003
13. О.Батсайхан, Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд (1911-1946), УБ, 2005

14. Е.М. Даревская, Россия и страны Востока в середине XIX-начале XX вв, Иркутск, 1984
15. Е.А. Белов, Россия и Китай в начале XX века, Русско-китайские противоречия в 1911-1915 гг, Москва, 1997
16. Г.Жамсранжав, Богд хаан, (Хурмаст хааны элч), УБ, 1998
17. Annual Register, London, 1906
18. Өнөөдөр сонин, 1998.5.2, № 88 /382/
19. Ц.Дамдиндорж, Түүвэр зохиол, "Өвгөн Жамбалын яриа", УБ, 1969
20. Б.Ширэндэв, Сэрэл, УБ, 1990
21. И.Н. Коростевец, От Чингис хана до Советской Республики, УБ, 2004
22. Журнал "Священный Байкал, Улан-УдэСпецномер, 1995
23. Новый Восток журнал, Москва, 1923